



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 11426

Арвайхээр

Г
Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс
урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 29.1.6-ын “а”, 29.1.6-ын “л”, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Сант, Баянгол, Нарийнтээл зэрэг сумдад отрын малын хөлөөр дамжин орж ирсэн мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний халдварлалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны дотор Мал эмнэлгийн газартай хамтран шуурхай зохион байгуулж, өвчний голомттой бус нутаг болон дархлаажуулалт хийгдсэн нутагт “Вакцин”-ы дархлаа тогтох хүртэл хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоож, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдах, тээвэрлэхийг хориглох шийдвэр гарган хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга наарт даалгасугай.

2. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100909

D:My Doc. Zahiramj. Zasag darga